

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/31 дүгээр зүйлийн 31.1.12 дахь заалт:**

“31.1.12.аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх;”

#### **2/31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг:**

“31.2.Дүүргийн Засаг дарга тухайн дүүргийн боловсролын хэлтсийн даргыг нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлийн сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн нийслэлийн боловсролын газрын даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.”

**2 дугаар зүйл.**Боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.12 дахь заалтын дугаарыг “31.1.13” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2017 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Бага, дунд боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 20.1.7 дахь заалт нэмсүгэй:

“20.1.7.сургуулийн барилга байгууламж дахь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байр, талбай, тоног төхөөрөмжийг нийтийн өмчийг ашиглах, эзэмших, захиран зарцуулахтай холбоотой хууль тогтоомж, эрх зүйн актаар тогтоосон журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалтаар зориулалтаар нь түрээслүүлэх.”

Гарын үсэг

## **БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ, БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг төслүүд Улсын Их Хурлаар батлагдсанаар тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцохдоо нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа заалтаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдэд шинэ чиг үүрэг бий болгосон эсэхийг үндэслэсэн болно.

Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдээр ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч, дүүргийн боловсролын хэлтсийн даргыг томилох, чөлөөлөхтэй холбоотой аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарын бүрэн эрхэд өөрчлөлт оруулж байгаа бөгөөд энэхүү өөрчлөлтөөс хамааран иргэд, боловсролын байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад шинээр болон нэмэлтээр чиг үүрэг бий болгоогүй тул нэмэлт зардал үүсгэхгүй юм.

---oOo---